



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 98

Ховд

Хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.3, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн 2016 оны батлагдсан төсөвт тодотгол хийх тухай Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг 2016 оны 10 дугаар сарын 21 -ны өдрийн 09.00 цагаас Ховд хотод хуралдуулсугай.

2. Хуралдаанаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

2.1. Аймгийн ИТХ-ын Хуралдааны байнгын дэгийг батлах тухай

2.2. Аймгийн 2016 оны Төсөвт тодотгол хийх тухай илтгэл.

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Д.Галсандондог

3. Хуралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч / Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 99

Ховд

Өмчийн албаны чиг үүргийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 5 дугаар заалт "нутгийн удирдах байгууллагад орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ажилтан буюу ажлын алба уг ажлыг эрхэлнэ" гэсэн заалт хүчингүй болсонтой холбогдуулан 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс тасалбар болгон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн эдийн засаг, үйлдвэрлэл өмчийн харилцааны хэлтсийн өмчийн албаны чиг үүргийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 183 дугаар тогтоолын 1 дүгээр заалтаас "өмчийн харилцаа", 2012 оны 199 дүгээр тогтоолоор баталсан аймгийн ИТХ-ын 2013-2016 оны стратегийн төлөвлөгөөний эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дагнасан үйл ажиллагааны хэсгээс "өмчийн харилцааны чиг үүрэг" гэсэн заалтыг тус тус хассугай.

3. Өмчийн албаны чиг үүрэг шилжихтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

3.1. Аймгийн ИТХ-ын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн бүрэлдэхүүнд батлагдсан өмчийн албаны 2016 оны төсвийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргын төсвийн бүрэлдэхүүнд шилжүүлэн батлуулах;

3.2. Өмчийн албаны чиг үүргийг гүйцэтгэхэд ашиглаж байсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны балансад бүртгэлтэй хөрөнгийг аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн газарт балансаас балансад шилжүүлэх;

3.3. Өмчийн албаны чиг үүргийг гүйцэтгэж байсан ажилтнуудтай холбогдох тооцоо хийж дуусган аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн газарт шилжүүлэх;

3.4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн эдийн засаг, үйлдвэрлэл өмчийн харилцааны хэлтэст харъяалагдан ажиллах үеийн өмчийн албаны архивыг зохих журмаар бүрдүүлэн хадгалалтанд шилжүүлэх;

4. Өмчийн албаны чиг үүрэг шилжиж байгаатай холбогдуулан шилжин очиж байгаа ажилтнуудын ажлын байрыг хадгалж үргэлжлүүлэн ажиллуулахыг аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 100

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа "Цэхээн булаг" нөхөрлөлийн оёдолчин Ядамцоо овогтой Тэрбишийг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 101

Ховд

Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Аймгийн шагналын журам батлах тухай" 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|--------------------------|---|
| 1. Дамдинбазар Батжаргал | - Зэрэг сумын ЕБС-ийн технолгийн багш |
| 2. Тумаг Энхсайхан | - Зэрэг сумын хүүхдийн цэцэрлэгт нярав |
| 3. Загджав Нямжав | - Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн багш |
| 4. Авир Цэвэлмаа | - Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн багш |
| 5. Чойжамц Батцагаан | - Жаргалант сумын 6 дугаар сургуулийн үйлчлэгч |
| 6. Надмид Ханджав | - Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн багш |
| 7. Жамба Пүрэвдорж | - Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн дуу хөгжмийн багш |
| 8. Г.Доржсүрэн | - Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн сахиул |
| 9. Дэмпээ Рагчаа | - Жаргалант сумын 12 жилийн 3 дугаар сургуулийн биеийн тамирын багш |
| 10. Жадамбаа Долгоржав | - Буянт сумын хүүхдийн цэцэрлэгт нярав |
| 11. Гончиг Сурмаа | - Үенч сумын хүүхдийн цэцэрлэгт туслах багш |
| 12. Батчулуун Тогтохбаяр | - Үенч сумын хүүхдийн цэцэрлэгт туслах багш |

13. Цэрэндагва Энхцэцэг - Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэгт туслах багш
14. Мөнхбаяр Чимгээ - Номын санд номын санч, мэдээллийн ажилтан

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 102

Ховд

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн а, 20 дугаар зүйлийн 20.1.1, Ховд аймгийн ногоон хөгжлийн бодлогын баримт бичгийг батлуулах тухай аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн “Хуралдаан зарлах тухай” 98 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн хэлэлцэх асуудлын 2.3-т “Ховд аймгийн ногоон хөгжлийн /2016-2026 он / хөтөлбөр батлах тухай” илтгэл

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Д.Галсандондог гэж нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2. Хуралдааны хэлэлцэх асуудалд орж буй нэмэлт, өөрчлөлтийг олон нийт, Төлөөлөгчдөд мэдээллэж хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г. ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 103

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 2016 оны “Өмчийн албаны чиг үүргийг шилжүүлэх тухай” 99 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны балансад бүртгэлтэй шинээр байгуулагдсан Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэх Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн өмчийн албаны чиг үүргийг гүйцэтгэхэд ашиглаж байгаа 6154300 төгрөгийн хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар, “Мянган угалзат” ОНӨААТҮГ-т гэрээгээр ашиглуулж байгаа 5810944880 төгрөгийн хөрөнгийг 2 дугаар хавсралтаар, “Соронзон нет” ХХК-д түрээсээр ашиглуулж байгаа 143511203 төгрөгийн хөрөнгийг 3 дугаар хавсралтаар, “Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын ахуй үйлчилгээний 847371542 төгрөгийн хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар, аймгийн Авто тээврийн газраас хүлээн авсан 70783875 төгрөгийн хөрөнгийг 5 дугаар хавсралтаар, дуусаагүй барилга байгууламжаар бүртгэгдсэн 1211841739 төгрөгийн хөрөнгийг 6 дугаар хавсралтаар тус тус баталж нийт 149 нэр төрлийн 8090607539 /найман тэрбум ерөн сая зургаан зуун долоон мянга таван зуун гучин есөн/ төгрөгийн хөрөнгийг

аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт балансаас
балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлж буй хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж зохих журмын дагуу хүлээлцүүлэн нийт 149 нэр төрлийн 8090607539 төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хасахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д зөвшөөрч, хөрөнгийг хүлээн авах комиссыг томилон нийт 149 нэр төрлийн 8090607539 төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авч ашиглалтыг хариуцаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 104

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа Онцгой байдлын газрын харъяа Мөст суман дахь Улсын нөөцийн салбарын засварын инженер Даваа овогтой Цагаандаржааг Монгол Улсын төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 105

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|-------------------------|---|
| 1. Дамдинсүрэн Саруул | - ХИС-ийн БШТС-ийн математикийн тэнхимийн ахлах багш |
| 2. Дүгэрсүрэн Батцэцэг | - ХИС-ийн БШТС-ийн газарзүйн тэнхимийн багш |
| 3. Уртбаяр Оюунчимэг | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга |
| 4. Мягмар Баатархүү | - Зэрэг сумын 12 жилийн дунд сургуулийн түүх, нийгмийн багш |
| 5. Дагва Хишгээ | - Зэрэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн багш |
| 6. Боголцог Отгонбаатар | - ХИС-ийн БШТС-ийн биологийн тэнхимийн Эрхлэгч |
| 7. Чантуу Аюурзана | - ХИС-ийн БШТС-ийн газарзүйн тэнхимийн эрхлэгч |

ХУРЛЫН ДАРГА *Г. Пүрэвганди* Г. ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 106

Ховд

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны “Журам батлах тухай” 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/. 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг:

2.2.4. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх газруудыг Худалдааны газар, түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5021-2007, Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946-2005, Худалдааны агуулах ерөнхий шаардлага MNS 5364-2011 стандартуудын шаардлагыг аймгийн төвийн суманд 90,0 хувь, бусад суманд 85,0 хувь хангасан тухай Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээчийн үнэлгээ”

2/. 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг:

2.7. “Худалдаа үйлчилгээний батлагдсан стандартыг зөрчсөн тохиолдолд Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээчдийн үнэлгээг үндэслэн зөвшөөрөл олгох комисс 14 хоногийн хугацаатай үл тохирол арилгах мэдэгдлийг хүргүүлэх ба хугацаандаа үл тохирлоо арилгаагүй бол зөвшөөрлийг хүчингүй

болгуулахаар аймгийн Засаг даргад санал оруулна. Хугацаандаа үл тохирол нь арилж стандартад нийцсэн тохиолдолд зөвшөөрлийг сэргээнэ”

3/. 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг:

2.8. “Дараах тохиолдолд Цагдаагийн газар, комиссын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар зөвшөөрлийг хүчингүй болгоно”

4/. 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийн:

2.8.5. “Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээчдийн үнэлгээг үндэслэн зөвшөөрөл олгох комиссын 14 хоногийн хугацаатай үл тохирлыг арилгах мэдэгдлийг биелүүлээгүй”

5/. 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсгийн:

3.7. “Согтууруулах ундааг аймгийн Засаг даргын шийдвэрээр тогтоосон цагаас бусад хугацаанд худалдах, үйлчлэхийг хориглох”

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны “Журам батлах тухай” 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.8-ийн 2.8.5 гэснийг 2.8.3 гэж өөрчилсүгэй.

3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны “Журам батлах тухай” 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.4, 2.7, 2.8, 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтыг 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс тус, тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай тогтоолыг 2016 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

5. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д орсон өөрчлөлтийг аж ахуй эрхлэгчид, иргэдэд мэдээлэн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д тус, тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЛҮРЭВГАНДИ



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 107

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Алтан гадас одон”-гоор

- | | |
|----------------------|---|
| 1. Гангаа Цэцэгмаа | - Булган сумын 1- дүгээр сургуулийн Физикийн багш |
| 2. Лхамжав Балжинням | - Аймгийн Хөгжимт Драмын Театртын жүжигчин |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- | | |
|-------------------------|---|
| 1. Цэцэгжав Дулам | - Жаргалант сумын 12 жилийн 6 дугаар сургуулийн үйлчлэгч |
| 2. Ойлоо Эрдэнэцогт | - Жаргалант сумын 12 жилийн 6 дугаар сургуулийн үйлчлэгч |
| 3. Сүхбаатар Наранчимэг | -Жаргалант сумын 12 жилийн 6 дугаар Сургуульд бага ангийн багш |
| 4. Батжаргал Анхбаяр | - Жаргалант сумын 12 жилийн 6 дугаар сургуулийн биеийн тамирын багш |
| 5. Дандан Төртогтох | - Жаргалант сумын 12 жилийн 6 дугаар сургуулийн дүрслэх урлагийн багш |

6. Гомпил Алтанцэцэг - Булган сумын 12 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш
7. Чойнзор Чулуунбаатар - Булган сумын 12 жилийн 1 дүгээр сургуулийн нярав
8. Баасанжав Чулуунцэцэг - Мянгад сумын сургуулийн дотуур байрны жижүүр
9. Охиндоо Халтархүү - Дөргөн сумын 12 жилийн сургуулийн нярав

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 108

Ховд

Ажлын албаны бүтэц,
орон тоог батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтцийг Нутгийн удирдлага, бодлого, зохицуулалтын болон Олон нийт, иргэдтэй харилцах хэлтэстэй байхаар тогтоож ажилтны орон тоог 14 хүртэл байхаар баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтцийн зохион байгуулалтын ерөнхий бүдүүвчийг 1 дүгээр хавсралтаар, Хурлын дарга болон Тэргүүлэгчдийн ажлын албаны дарга, хэлтсүүдийн үйл ажиллагааны чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д үүрэг болгох нь:

1/. Байгууллагын 2016-2021 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангах

2/. Ажлын албаны шинэчилсэн бүтцээр ажилтнуудын ажлын байрны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй хэрэгжих оновчтой зохион байгуулалтанд шилжүүлэн, ажиллах боломжийг бүрдүүлж ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах

3/. Тэргүүлэгчдийн ажлын албаны шинэ бүтцээр ажиллахад шаардлагатай төсвийг аймгийн жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж байх

4. Ажлын албаны шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, үр дүнгийн гэрээ байгуулж чиг

үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

5. Тус тогтоолыг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

6. Тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны "Ажлын албаны бүтэц, орон тоо батлах тухай" 183 дугаар тогтоолыг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 109

Ховд

Тэтгэмж олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит бус хуралдааны 03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн 2012-2016 онд аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Бямбын Баярсайхан, аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Дамдиндоржийн Цэвээнравдан, Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Морхын Амарсанаа, Чимэдийн Чинбат нарт албан тушаалын 6 сарын хугацааны цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгосугай.

2. Б.Баярсайханы тэтгэмжийг аймгийн ИТХ-ын төсвөөс, Д.Цэвээнравдан, М.Амарсанаа, Ч.Чинбат нарын тэтгэмжийг аймгийн төсвөөс тус тус гаргаж олгохыг аймгийн ИТХ-ын дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Г.Пүрэвганди/, аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөгч захирагч /Д.Галсандондог/ нарт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 110

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын гавъяат багш цол”-оор

1. Даваажамц Баттулга - Жаргалант сумын Прогресс дунд сургуулийн сургалтын менежер

“Алтан гадас одон”-гоор

1. Мэндбаяр Мөнх-Очир - Дуут сумын Цагаанбургас багийн ахмад настан

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 111

Ховд

Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Аймгийн шагналын журам батлах тухай" 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнасугай. Үүнд:

- | | |
|---------------------------|--|
| 1. Ням Дарьжав | - Мянгад сумын Цагаанбулан багийн ахмад настан |
| 2. Жанцан Цэрэнхүү | - Мянгад сумын Чацарганат багийн ахмад настан |
| 3. Төмөрбаатар Тэгшжаргал | - Геологи шинжилгээний "Алтай нэгдэл" ХК-д техник геологич |
| 4. Содов Шарав | - Геологи шинжилгээний "Алтай нэгдэл" ХК-д сахиул |
| 5. Лхамхүү Мөнхнасан | - Дуут сумын Босго багийн ахмад настан |
| 6. Цэвэгжав Баянмөнх | - Дуут сумын Хөхбэлчир багийн малчин |
| 7. Булгаа Мөнхбат | - Дуут сумын Цагаанбургас багийн малчин |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

20/6 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 112

Ховд

Хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.5, 23 дугаар зүйлийн 23.4, Газрын тухай хуулийн 20.1.2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, 64.1.3 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааныг 2016 оны 12 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд аймгийн Нутгийн удирдлагын ордны Хуралдааны Их танхимд хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1/ Аймгийн ИТХ-ын 2016 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай

Илтгэгч нь: аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди

2/ Аймгийн Засаг даргын 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2016 оны үндсэн чиглэлийн биелэлт, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Д.Галсандондог

3/ Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2017 оны үндсэн чиглэлийг батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Д.Галсандондог

4/ Аймгийн 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2017 оны төсвийн төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Д.Галсандондог

5/ Аймгийн Аудитын газраас орон нутгийн 2017 оны төсвийн төсөлд болон төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар өгөх санал

Илтгэгч нь: Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрах

6/ Аймгийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай

Илтгэгч нь: Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э. Дөлбадрал

2.Хуралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 113

Ховд

Ой тэмдэглэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 151 дүгээр зарлиг, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, комиссын нарийн бичгийн даргын албан бичгээр ирүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Үндсэн хуулийн 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/, Засаг дарга /Д.Галсандондог/ нарт үүрэг болгох нь:
 - 2.1. Ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг томилж баярын арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах.
 - 2.2. Ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай төсвийг аймгийн 2016 оны батлагдсан төсвөөс зохицуулалт хийж санхүүжүүлэх
 - 2.3. Аймгаас Ардын Их Хурлын депутатаар сонгогдож шинэ Үндсэн хууль батлалцсан депутатуудын дурсамжийн номыг хэвлүүлэхэд шаардлагатай төсвийг аймгийн 2017 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах.

ХУРЛЫН ДАРГА /Г.Пүрэвганди/ Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 114

Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусч, цаашид ашиглах боломжгүй 2003 онд ашиглалтанд орсон 1500.0 мянган төгрөг /нэг сая таван зуун мянга/-ийн балансын үнэ бүхий модон хашааг акталж хөрөнгийн бүртгэлээс хасахыг Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /Б.Төгсжаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 115

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, “Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ-ын хүсэлт болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жаргалант сумын Багийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гэр хорооллын хог хаягдлыг тээвэрлэх зориулалттай 2013 онд ашиглалтанд орсон, тус бүр нь 14100.0 мянган төгрөгийн 42300.0 төгрөг /дөчин хоёр сая гурван зуун мянга/-ийн балансын үнэтэй, 14100.0 мянган төгрөг /арван дөрвөн сая нэг зуун/-ийн хуримтлагдсан элэгдэлтэй хавсралтанд тусгагдсан 3 автомашиныг “Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ-азарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж зохих журмын дагуу хүлээлцүүлэн бүртгэлээс хасах болон бүртгэлд тусгах өөрчлөлт хийхийг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Ариунбилэг/, “Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ-ын дарга /П.Мягмартүвшин/ нарт үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 115

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 77 дугаар зүйлийн 77.3 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан журмын 4 дугаар зүйлийн 4.2 дахь заалт, Буянт сумын ИТХ, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Буянт сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 2011 онд ашиглалтанд орсон 6595700 төгрөг /зургаан сая таван зуун ерэн таван мянга долоон зуу/-ийн балансын үнэ бүхий 4946800 төгрөг /дөрвөн сая есөн зуун дөчин зургаан мянга найман зуу /-ийн үлдэх өртөгтэй гүний худгийг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнөөс хасаж тус сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөрөнгийг хүлээлцүүлэн данс бүртгэлээс хасахыг Буянт сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Даваатогтох/-д зөвшөөрч, хөрөнгийг комисс томилон хүлээн авч балансад бүртгэн ашиглалтыг хариуцаж ажиллахыг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 116

Ховд

Нийтийн дуудлага худалдаа зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын балансад бүртгэлтэй УАЗ-31512 маркийн 24-22 ХОА улсын дугаартай суудлын авто машины нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Ховд сумын Засаг даргын Тамгын Газарт зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 117

Ховд


Нийтийн дуудлага худалдаа зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Манхан сумын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй УАЗ-31512 маркийн 48-06 ХОА улсын дугаартай суудлын авто машины нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Манхан сумын Засаг даргын Тамгын газарт зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 118

Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын 2013 оны 30 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2, Манхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, сумын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ашиглалтын явцад элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, элэгдэж цаашид ашиглах боломжгүй болсон акталж данснаас хасах Манхан сумын Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд буй 3 нэр төрлийн 2.239.0 мянган төгрөг / хоёр сая хоёр зуун гучин есөн мянга/-ийн, Эрүүл мэндийн төвийн 1 төрлийн 850.0 мянган төгрөг /найман зуун тавин мянга/-ийн, Цэцэрлэгийн 850.0 мянган төгрөг /найман зуун тавин мянга/-ийн, Ерөнхий боловсролын сургуулийн 1300.0 мянган төгрөг /нэг сая гурван зуун мянга/-ийн, сумын Соёлын төвийн 1333.6 мянган төгрөг /нэг сая гурван зуун гучин гурван мянга зургаан зуун /-ийн үнэ бүхий ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон хавсралтад заасан тоног төхөөрөмжийг бүртгэлээс хасахыг Манхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Т.Сайнбаяр/, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч /Г.Насанбат/, Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Я.Соёл-Эрдэнэ/, Соёлын төвийн эрхлэгч /Т.Цэрэнбадам/ нарт зөвшөөрсүгэй.

2. Ашиглалтнаас хасаж буй хөрөнгийн борлуулах боломжтой хэсгийг сумын өмч хамгаалах зөвлөлөөс үнэ тогтоон борлуулж сумын төсөвт оруулан, хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг Манхан сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга /Ц.Сонинцээ/, Засаг даргын тамгын газрын дарга /Т.Сайнбаяр/, эрүүл мэндийн

төвийн эрхлэгч эмч /Г.Насанбат/, Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Я.Соёл-Эрдэнэ/ нарт зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 119

Ховд

Нийтийн дуудлага худалдаа
дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 14, 53 дугаар тогтоолоор тогтоосон дуудлага худалдааны үнийг бууруулж нийтийн дуудлага худалдаа дахин зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах Ховд сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар Зэрэг сумын засаг даргын Тамгын газрын хөрөнгийн жагсаалтын 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Ховд сумын Засаг даргын Тамгын газрын байранд, 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын байранд тус тус зохион байгуулсугай.

4. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгүүдийг зохих журмын дагуу дуудлага худалдаагаар худалдаж худалдан авагчид шилжүүлэн өгч данс бүртгэлээс хасахыг Ховд, Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

5. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 120

Ховд

Нийтийн дуудлага худалдаа
дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 53 дугаар тогтоолоор тогтоосон дуудлага худалдааны үнийг бууруулж нийтийн дуудлага худалдааг дахин зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдаагаар дахин худалдах хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Жаргалант сумын автомашины нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 06 -ны өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд, Алтай сумын автомашины нийтийн дуудлага худалдааг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Алтай сумын Засаг даргын Тамгын газрын байранд тус тус зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах автомашинуудыг зохих журмын дагуу дуудлага худалдаагаар худалдаж худалдан авагчид шилжүүлэн өгч данс бүртгэлээс хасахыг Жаргалант, Алтай сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан

борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 121

Ховд


Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн хэрэгцээнд зориулан 2015 онд баригдсан 780.0 /долоон зуун наян мянга/ төгрөгийн өртөгтэй агуулахын барилгыг Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэж авахыг Цэцэрлэгийн эрхлэгч /Б.Төгсжаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 122

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 77 дугаар зүйлийн 77.3 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан журмын 4 дугаар зүйлийн 4.2 дахь заалт, Буянт сумын ИТХ, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Буянт сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 2011 онд ашиглалтанд орсон 6595700 төгрөг /зургаан сая таван зуун ерэн таван мянга долоон зуу/-ийн балансын үнэ бүхий 4946800 төгрөг /дөрвөн сая есөн зуун дөчин зургаан мянга найман зуу /-ийн үлдэх өртөгтэй гүний худгийг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнөөс хасаж тус сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөрөнгийг хүлээлцүүлэн данс бүртгэлээс хасахыг Буянт сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Даваатогтох/-д зөвшөөрч, хөрөнгийг комисс томилон хүлээн авч балансад бүртгэн ашиглалтыг хариуцаж ажиллахыг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 123

Ховд

Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Мөнх амийн амьд үг” Баптист сүмийн үйл ажиллагаа явуулах эрхийг 2017 оны 11 дүгээр сарын 17-нийг хүртэл 1 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа “Ховд аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг удирдлага болгон ажиллахыг “Мөнх амийн амьд үг” Баптист сүмийн ахлагч /Б.Ганболд/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 124

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Алтан гадас одон”-гоор

1. Алтангэрэл Наранцэцэг - Аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газрын технологийн сургалт хариуцсан мэргэжилтэн

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Соном Оюундэлгэр - Аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газрын төсөв санхүү хариуцсан мэргэжилтэн
2. Минап Бердигүл - Аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газрын гадаад хэлний сургалт хариуцсан мэргэжилтэн

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 125

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам батлах тухай” 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

1. Самдан Дашхүү - “Улам дэлгэрэх” төгөл нөхөрлөлийн тэргүүн
2. Жамцаадорж Зоригтбаатар - Жаргалант сумын Цамбагарав багийн иргэн
3. Надмид Дэмид - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт нярав
4. Цагаанхүү Долгор - Дуут сумын Шивэр багийн малчин
5. Пүрэв Цэрмаа - Дуут сумын Цагаанбургас багийн малчин
6. Мамад Энхбаяр - Дуут сумын Хөхбэлчир багийн малчин
7. Заграа Нямаахүү - Дуут сумын Хөхбэлчир багийн малчин
